

**Аймгийн удирдах ажилтнуудын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2024.01.19

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Сумдын Засаг дарга оторт гарсан өрхүүдээр тойрч малчидтай уулзалт хийх.	2024.01.22	Говьсүмбэр аймгийн хэмжээнд нийт 72 малчин өрхийн 45639 толгой мал отроор өвөлжиж байна. Тэдний 66 өрхийн 40633 толгой мал Дундговь аймагт, 4 өрхийн 4574 толгой мал Хэнтий аймагт, 2 өрхийн 432 толгой мал Дорнод аймагт байна. Сүмбэр сумын Засаг дарга 01 сарын 08-09-ны өдрүүдэд отроор өвөлжиж байгаа 15 өрхтэй уулзаж нөхцөл байдалтай танилцан сумын малчин өрхүүдэд үнэгүй өвс, тэжээл тараах шийдвэр гаргасан. Шивээговь сумын Засаг дарга 2024 оны 01 дүгээр сарын 04, 01 дүгээр сарын 09-ны өдрүүдэд 27 малчин өрх, 9 отрын айл өрхтэй уулзсан.	70
2	Аймаг байгуулагдсаны 30 жилийн ойг угтан нийгмийн хариуцлагын хүрээнд бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, төлөвлөгөөг НБХ-т хүргүүлэх.	2024.01.22	2024.01.22-ны өдрийн байдлаар 10 байгууллага холбогдох төлөвлөгөөг боловсруулан НБХ-т ирүүлсэн байна. Үүнд: - Сүмбэр сумын ЗДТГ - Татварын хэлтэс - Эрүүл мэндийн газар - Боржигин өв музей - Насан туршийн боловсролын төв - Ус-Ду ОНӨААТҮГ - Улсын бүртгэлийн хэлтэс - Хүнс, хөдөө, аж ахуйн газар - Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар - Байгаль орчин, аялал жуулчлалын газар	30

3	Өвс, тэжээлийн нөөцийг хуулийн хүрээнд бүрдүүлэн малчдад дэмжлэг үзүүлэх	2024.01.22	<p>Аймгийн аюулгүйн нөөцөд 140 тн өвс нөөцөлсөн.</p> <p>Сүмбэр сумын малчин өрхүүдийн 1 өрхөд 10 боодол өвс, 3 шуудай тэжээл олгох хуваарийн дагуу 569 малчин өрхөд 5690 боодол буюу 125,18 тн өвс, 1707 шуудай буюу 42,67 тн тэжээлийг үнэ төлбөргүй олгосон.</p> <p>Баянтал сумын нөөцөд 750 боодол буюу 16.8 тн өвс, 100 шуудай буюу 2.4 тн тэжээл байна.</p> <p>Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу Баянтал суманд 545 боодол буюу 11.9 тн өвс, 279 шуудай буюу 6.9 тн тэжээл аймгийн нөөцөөс олгосон. 40 малчин өрхөд тус бүр 10 боодол өвс, 3 шуудай тэжээлийг тарааж, нийт 400 боодол буюу 8.8 тн өвс, 120 шуудай буюу 2.9 тн тэжээл, 30 мал бүхий өрхөд тус бүр 5 боодол өвс, 1 шуудай тэжээлийг тарааж, нийт 150 боодол буюу 3.3 тн өвс, 60 шуудай буюу 1.4 тн тэжээлийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Шивээговь сумын 105 малчин өрхөд тус бүр 10 боодол өвс, 3 шуудай тэжээлийг тарааж, нийт 1050 боодол буюу 23.1 тн өвс, 315 шуудай буюу 7.8 тн тэжээлийн туслалцаа үзүүлээд байна.</p>	100
Дундаж			66.6	

Хянасан: ХШҮХ-ийн дарга

М.Анхбаяр

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:

ХШҮХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа